



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТОГТООЛ

2026 оны 05 сарын 08 өдөр

дугаар 03

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухайн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.32.16 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 05 сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ТЭСО” ХХК-ийн “Хаан Банк” ХК-аас авч буй нийт 29,000,000,000 (хорин есөн тэрбум) төгрөгийн 24 сарын хугацаатай, төгрөгийн жилийн 1.0 хувийн коммитмент хүүтэй, дор дурдсан нөхцөлөөр олон зориулалттай зээлийн эрхийн барьцаанд “Хөсөг Трейд” ХК-ийн улсын бүртгэлийн Э-2205002334, нэгж талбарын 1681600482 дугаартай газар болон улсын бүртгэлийн Y-2205011243 дугаартай үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.

1.1. 12 сар хүртэлх хугацаатай, төгрөгийн жилийн 16.8 хувийн хүүтэй зээлийн шугам;

1.2. 6 сар хүртэлх хугацаатай, төгрөгийн жилийн 16.8 хувь, ам.долларын жилийн 9.6 хувийн хүүтэй ачилтын өмнөх болон дараах зээл;

1.3. 12 сар хүртэлх хугацаатай, төгрөгийн болон ам. долларын жилийн 2.0 хувийн хүүтэй гадаад/дотоод баталгаа, аккредитив.

2. Дээр дурдсан зээлүүдийн барьцаанд тавих Хөсөг трейд ХК-ийн газар болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг энэхүү тогтоолын хавсралт №1-д зааснаар тогтоож барьцаалахыг зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан газар болон үл хөдлөх хөрөнгө барьцаалах хэлцэл нь их хэмжээний хэлцэл болохыг дурдсугай.

4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу барьцааны гэрээ болон бусад холбогдох бүхий л баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

С.БОЛОР



Хөсөг трейд ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 01 сарын 08-ны өдрийн 08 тоот тогтоолын хавсралт №01

№	Товч тайлбар	Байршил	Талбайн хэмжээ, м.кв	Улсын бүртгэл, гэрчилгээний дугаар	Эзэмшил	Барьцааны зүйлийн ЭТҮ ₮	ЭТ%	Зах зээлийн үнэлгээ ₮
1	Контор, авто үйлчилгээ	БГД 20-р хороо, ТЭЦ-3, баруун талд	8,728	Ү-2205011243	Хөсөгтрейд ХХК	10,373,237,000	60%	17,288,728,333
2	Газар		53,329	Э-2205002334		2,107,802,800	40%	5,269,507,000
	Нийт					12,481,039,800		22,558,235,333

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



С.БОЛОР



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТОГТООЛ

2026 оны 05 сарын 08 өдөр

дугаар 04

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 7.32.17 дэх заалт болон болон 2026 оны 05 сарын 08-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ТЭСО” ХХК-ийн “Хаан Банк” ХК-аас авч буй нийт 29,000,000,000 (хорин есөн тэрбум) төгрөгийн 24 сарын хугацаатай, төгрөгийн жилийн 1.0 хувийн коммитмент хүүтэй, дор дурдсан нөхцөлөөр олон зориулалттай зээлийн эрхийн барьцаанд “Хөсөг Трейд” ХК-ийн улсын бүртгэлийн Э-2205002334, нэгж талбарын 1681600482 дугаартай газар болон улсын бүртгэлийн Y-2205011243 дугаартай үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.


- 1.1. 12 сар хүртэлх хугацаатай, төгрөгийн жилийн 16.8 хувийн хүүтэй зээлийн шугам;
- 1.2. 6 сар хүртэлх хугацаатай, төгрөгийн жилийн 16.8 хувь, ам.долларын жилийн 9.6 хувийн хүүтэй ачилтын өмнөх болон дараах зээл;
- 1.3. 12 сар хүртэлх хугацаатай, төгрөгийн болон ам. долларын жилийн 2.0 хувийн хүүтэй гадаад/дотоод баталгаа, аккредитив.

2. Дээр дурдсан зээлүүдийн барьцаанд тавих Хөсөг трейд ХК-ийн газар болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг энэхүү тогтоолын хавсралт №1-д зааснаар тогтоож барьцаалахыг зөвшөөрсүгэй.

3. Энэхүү хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэл тул ТУЗ-ийн гишүүн Д.Бадам, С.Жавзан-Орлом, С.Бат-Өлзий, С.Болор, Ж.Гантогтох, Г.Маргад нарын хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл болохын хувьд эдгээр гишүүдээс бусад бүх гишүүд санал нэгтэй зөвшөөрсөн болохыг тэмдэглэсүгэй.

4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу барьцааны гэрээ болон бусад холбогдох бүхий л баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д олгосугай.

ГИШҮҮД



Ц.ДАМЖИН

Т.ӨЛЗИЙБҮРЭН

Р.ГАНСҮХ

Хөсөг трейд ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 05 сарын 04-ны өдрийн 04 тоот тогтоолын хавсралт №01

№	Товч тайлбар	Байршил	Талбайн хэмжээ, м.кв	Улсын бүртгэл, гэрчилгээний дугаар	Эзэмшил	Барьцааны зүйлийн ЭТҮ ₮	ЭТ%	Зах зээлийн үнэлгээ ₮
1	Контор, авто үйлчилгээ	БГД 20-р хороо, ТЭЦ-3, баруун талд	8,728	Ү-2205011243	Хөсөгтрейд ХХК	10,373,237,000	60%	17,288,728,333
2	Газар		53,329	Э-2205002334		2,107,802,800	40%	5,269,507,000
	Нийт					12,481,039,800		22,558,235,333